

БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ТОГТООХ ТУХАЙ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Монгол Улсын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 4 дэх заалтад заасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг ББСБ-аас ханган биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих болон хариуцлага хүлээлгэх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Энэхүү журамд хэрэглэгдсэн нэр томъёог дараах утгаар ойлгоно. Үүнд:

1/ "Холбогдох этгээд" гэдгийг Банк бус санхүүгийн байгууллагын /цаашид ББСБ гэх/ хувь нийлүүлэгч, ТУЗ-ийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, тэдгээрийн өвөг эцэг, эмэг эх, эцэг, эх, эхнэр, нөхөр, ах, эгч, дүү болон тэдэнд хяналтын багцаа эзэмшүүлдэг хуулийн этгээд, уг хуулийн этгээдийн хяналтын багцыг эзэмшдэг иргэн, хуулийн этгээд гэж ойлгоно;

2/ "Төлбөрийн баталгаа гаргах" гэдгийг Иргэний хуулийн 457 дугаар зүйлд зааснаар;

3/ "Гадаад валютын ханшийн эрсдэл" гэж гадаад валютаар илэрхийлэгдсэн актив, пассив болон тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа гэрээ, хэлцлээр үүсч болзошгүй өглөг, авлагын дүн хоорондоо зөрүүтэй байх үед ханш хэлбэлзэхэд алдагдал хүлээх магадлалыг хэлнэ;

4/ "Гадаад валютын нээлттэй позиц" гэж тэнцлийн гадаад валютын активын үлдэгдэл, тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа гэрээ, хэлцлээр үүсч болзошгүй гадаад валютын авлагын нийлбэр болон тэнцлийн гадаад валютын пассивын үлдэгдэл, тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа гэрээ, хэлцлээс үүсч болзошгүй гадаад валютын өглөгийн нийлбэрийн цэвэр зөрүүг хэлнэ;

5/ "Гадаад валютын нээлттэй урт позиц" гэж тэнцлийн гадаад валютын актив, тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа гэрээ, хэлцлээс үүсч болзошгүй гадаад валютын авлагын нийлбэр нь тэнцлийн гадаад валютын пассив, тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа гэрээ, хэлцлээс үүсч болзошгүй гадаад валютын өглөгийн нийлбэрээс давсан хэсгийг хэлнэ;

6/ "Гадаад валютын нээлттэй богино позиц" гэж тэнцлийн гадаад валютын пассив, тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа гэрээ, хэлцлээс үүсч болзошгүй гадаад валютын өглөгийн нийлбэр нь тэнцлийн гадаад валютын актив, тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа гэрээ, хэлцлээс үүсч болзошгүй гадаад валютын авлагын нийлбэрээс давсан хэсгийг хэлнэ;

7/ “Гадаад валютын хаалттай позиц” гэж тэнцлийн гадаад валютын актив, тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа гэрээ, хэлцлээс үүсч болзошгүй гадаад валютын авлагын нийлбэр нь тэнцлийн гадаад валютын пассив, тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа гэрээ, хэлцлээс үүсч болзошгүй гадаад валютын өглөгийн нийлбэртэй тэнцүү байхыг хэлнэ;

8/ “Гадаад валютын нээлттэй позицийн лимит” гэж тухайн нэг гадаад валют болон нийт гадаад валютын хувьд үүссэн нээлттэй урт, богино позицийг ББСБ-ын өөрийн хөрөнгөд харьцуулан тогтоосон хязгаарлалтыг хэлнэ;

9/ “Хоёрдогч өглөг” гэж 5 жилээс дээш хугацаагаар санхүүгийн эх үүсвэр болгож хөрөнгө оруулагчдаас төвлөрүүлсэн хөрөнгийн дүн буюу уг хугацааны эцэст хувьцаанд хөрвөх өрийн бичгийг хэлнэ.

ББСБ татан буугдсан тохиолдолд хоёрдогч өглөгийг төлж барагдуулах дараалал нь Иргэний хуулийн 32.5.6 дугаар зүйлээр зохицуулагдана.

Хоёрдогч өглөгийг санхүүгийн тайланд тусгахын өмнө Санхүүгийн зохицуулах хороонд /цаашид Хороо гэх/ мэдэгдэж, холбогдох зөвшөөрлийг авсан байна.

Хоёрдогч өглөгийн үндсэн өрийг ББСБ-ыг татан буулгасан, ББСБ-ыг байгуулах зөвшөөрлийг хүчингүй болгосон, дампуурсан, төлбөрийн чадваргүй болсныг зарласан, өөрчлөн байгуулсан, Хорооноос урьдчилан зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд хугацаанаас нь өмнө барагдуулахыг хориглоно.

1.3 ББСБ нь үйл ажиллагаандаа дараах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тооцож ажиллана. Үүнд:

- 1/ өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт;
- 2/ төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа;
- 3/ актив хөрөнгийн төвлөрлийн эрсдэлийн зохистой харьцаа;
- 4/ гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа.

1.4 ББСБ нь дээрх зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг сар, улирал, жилийн санхүүгийн тайлан тэнцэлд үндэслэн үнэн зөв тооцож, тэдгээрийн өөрчлөлтөд нөлөөлсөн хүчин зүйлс, шалтгааныг тодорхойлон, санхүү, төлбөрийн чадварын байдлыг үнэлэн, учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах, түүнийг зохистой түвшинд барих арга хэмжээг авч ажиллана.

1.5 ББСБ нь дээр дурдсан үзүүлэлтүүдээс гадна үйл ажиллагаандаа учирч болзошгүй эрсдэлийг хянаж удирдах заавар, журмыг Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, энэхүү журамтай нийцүүлэн боловсруулж, дотооддоо мөрдөж болно.

ХОЁР. ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭ

2.1 Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт нь тухайн ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой бүхий л төрлийн эрсдэлийг хаах болон стратеги төлөвлөгөөнд

заасан зорилгыг биелүүлэхэд хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгө байгаа эсэхийг тодорхойлон харуулдаг.

2.2 Хорооноос тогтоосон өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт нь санхүүгийн холбогдолтой эрсдэлийг хаахад хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгө байгаа эсэхийг харуулах бөгөөд зээлийн, зах зээлийн, хөрвөх чадварын холбоотой эрсдэлийг хамруулан ойлгоно.

2.3. ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой алдагдлыг хувь нийлүүлэгч нарт хүлээж буй хариуцлагатай нь уялдуулан хуваарилах үүднээс өөрийн хөрөнгийг дараах байдлаар ангилна. Үүнд:

1/ *Í úääÿúúð çýðÿäÿëëéí °°ðëéí ð°ð°íã°* гэдэгт ердийн хувьцаа, нэмж төлөгдсөн капитал (ердийн хувьцаа), нөөцийн сан, хуримтлагдсан ашиг/алдагдал зэрэг орно.

2/ *Õî, ðäöäääð çýðÿäÿëëéí °°ðëéí ð°ð°íã°* гэдэгт давуу эрхтэй хувьцаа, нэмж төлөгдсөн капитал (давуу эрхтэй хувьцаа), дахин үнэлгээний нэмэгдэл, нийгмийн хөгжлийн сан, хоёрдогч өглөг зэрэг орно.

2.4. ББСБ-ын өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг тооцохоос өмнө энэхүү журмын 2.3-т заасан өөрийн хөрөнгийг дараах байдлаар тохируулсан байх ёстой. Үүнд:

1/урьдчилж төлсөн татварын дүнг нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс хасах;

2/хоёрдогч өглөгийн дүнг нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн 50 хувиар хязгаарлаж тооцох;

3/хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дүнг нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дүнгээс хэтрэхгүй байхаар тооцно;

4/урьдчилсан болон дараалсан хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчил, дутагдалтай холбоотой залруулгын гүйлгээг зохих дансанд хийж, өөрийн хөрөнгийн бодит дүнг гаргана.

2.5. Эрсдэлээр жигнэсэн нийт цэвэршүүлсэн активыг дараах байдлаар тооцно. Үүнд:

1/эрсдэлийн сан, хуримтлагдсан элэгдлээр цэвэршүүлсэн активууд болон тэнцлийн гадуурх дансаар хүлээж болзошгүй үүргүүдийг энэ журмын нэгдүгээр хавсралтад заасан эрсдэлийн хувь хэмжээгээр нь үржүүлж, нийлбэрийг тооцож гаргана;

2/гарсан нийлбэр дүн дээр зургадугаар хавсралтын дагуу тооцсон гадаад валютын актив пассивын нийт зөрүүг нэмнэ,

3/шаардлагатай бол энэ журмын 2.4-ийн 5/-д заасан болон бусад залруулгын гүйлгээг активын холбогдох дансуудад хийнэ.

2.6 ББСБ нь өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны үзүүлэлтийг “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.3 дахь заалтын дагуу эрхлэх үйл ажиллагааны төрлөөс хамаарч тооцно.

2.6.1. “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.3.1-д заасан төрлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий ББСБ-ын хувьд:

1/ Энэ журмын 2.4-т заасны дагуу тохируулсан нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн нийт цэвэршүүлсэн активын зохистой харьцаа нь 15 хувиас багагүй байна.

2/ Энэ журмын 2.4-т заасны дагуу тохируулсан нийт өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн нийт цэвэршүүлсэн активын зохистой харьцаа нь 30 хувиас багагүй байна.

2.6.2. “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.3.2-д заасан төрлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий ББСБ-ын хувьд:

1/ Энэ журмын 2.4-т заасны дагуу тохируулсан нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн нийт цэвэршүүлсэн активын зохистой харьцаа нь 20 хувиас багагүй байна.

2/ Энэ журмын 2.4-т заасны дагуу тохируулсан өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн нийт цэвэршүүлсэн активын зохистой харьцаа нь 40 хувиас багагүй байна.

2.7 ББСБ нь өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны тайланг энэхүү журмын нэгдүгээр хавсралтын дагуу тооцож гаргана.

2.8 Хороо нь шаардлагатай гэж үзсэн тохиолдолд ББСБ-ын өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцаанд энэхүү журамд заасан хэмжээнээс дээгүүр тогтоож болно.

ГУРАВ. ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР

3.1 Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар (цаашид “ТТГЧ” гэх) гэж бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг харилцагчийн анхны шаардлагаар буцаан олгох чадварыг хэлнэ. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны тайланг энэхүү журмын хоёрдугаар хавсралтын дагуу тооцож гаргана.

3.2 Касс дахь бэлэн мөнгө, банкин дахь харилцах, хадгаламж, Монголбанк болон Засгийн газрын үнэт цаас зэргийн нийлбэр дүнг "Түргэн борлогдох актив" гэнэ. Дампуурсан, төлбөрийн чадваргүй болсноос санхүүгийн хүндрэлд орсон банкин дахь харилцах, хадгаламжид байршуулсан хөрөнгийг түргэн борлогдох активт оруулан тооцохгүй.

Түргэн борлогдох активыг энэхүү журмын хоёрдугаар хавсралтын "А" хэсэгт заасны дагуу тооцож гаргана.

3.3 Банк, бусад санхүүгийн байгууллагаас авсан зээл, зээлийн хүүгийн өглөг, итгэлцэл, факторингийн үйлчилгээгээр үүссэн өглөг, гаргасан үнэт цаас, мөнгөн гуйвуулга, цахим төлбөр тооцооны үйлчилгээ, бусад пассив дансны үлдэгдлийн нийлбэр дүнг бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөд тооцно. Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг энэхүү журмын хоёрдугаар хавсралтын "Б" хэсэгт заасны дагуу тооцож гаргана.

3.4 Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтийг тооцохдоо түргэн борлогдох активыг бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөд харьцуулах бөгөөд уг зохистой харьцааг “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.3 дахь заалтын дагуу эрхлэх үйл ажиллагааны төрлөөс хамаарч биелүүлнэ.

3.4.1. “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.3.1-д заасан төрлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий ББСБ-ын хувьд зохистой харьцаа нь бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн 10 хувиас доошгүй байна.

3.4.2. “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.3.2-д заасан төрлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий ББСБ-ын хувьд зохистой харьцаа нь бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн 20 хувиас доошгүй байна.

3.5 Зөвхөн өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын хувьд энэ үзүүлэлтийг хангаж ажилласан гэж үзэх тул ТТГЧ-ын шалгуур үзүүлэлтийг тооцох шаардлагагүй.

ДӨРӨВ. АКТИВ ХӨРӨНГИЙН ТӨВЛӨРЛИЙН ЭРСДЭЛ

4.1 Зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн төвлөрлийн эрсдэлийг тухайн үйлчилгээг нэг болон цөөн этгээдэд хэт төвлөрүүлснээр зээл, зээлийн хүү, төлбөрийг эргүүлэн төлүүлж чадахгүйд хүрч, активын чанар муудан ББСБ-ын санхүүгийн чадвар доройтохоос сэргийлэх зорилгоор тооцно.

4.2 “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль”-д заасны дагуу нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтрэхгүй байна.

ББСБ-аас том зээлдэгчид олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн тайланг энэхүү журмын гуравдугаар хавсралтын дагуу гаргана.

4.3 ББСБ-ын хувь нийлүүлэгч, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, ажилтнууд тэдгээртэй холбогдох этгээд болон тэдний эзэмшлийн нэгжид олгох зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны дээд хэмжээ нь өөрийн хөрөнгийн 10 хувь, тэдгээрийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 25 хувиас тус тус хэтрэхгүй байна. Тайланг энэхүү журмын дөрөвдүгээр хавсралтын дагуу гаргана.

4.4 Зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн эрсдэлийн санг Монголбанкны Ерөнхийлөгч, СЭЗ-ийн сайдын хамтарсан 2004 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 459/207 тоот тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”, Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан 2006 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 147/94 тоот тушаалаар журамд оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу тооцож байгуулна.

Эрсдэлийн сангийн хүрэлцээний үзүүлэлтийн тайланг энэхүү журмын тавдугаар хавсралтын дагуу тооцож гаргана.

4.5 ББСБ-ын гаргасан төлбөрийн баталгааны нийт дүн өөрийн хөрөнгийн 70 хувиас хэтрэхгүй. Тэнцлийн гадуур бүртгэлтэй хүлээж болзошгүй үүрэг, төлбөрийн баталгааны тайланг энэхүү журмын долдугаар хавсралтын дагуу гаргана.

ТАВ. ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ЭРСДЭЛ

5.1 Гадаад валютын ханшийн тэгшитгэлээс хүлээж болох алдагдал нь ББСБ-ын санхүүгийн чадварт сөргөөр нөлөөлөх эсэхийг гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцааны үзүүлэлтээр тооцно.

5.2 Гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцааны үзүүлэлтийг нийт болон тухайн нэг гадаад валютын нээлттэй позици тус бүрээр нь тодорхойлно.

5.3 Нэг гадаад валютын хувьд нээлттэй позицийг тэнцлийн актив, пассивын ялгавар дээр тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа гэрээ, хэлцлээс үүсч болзошгүй авлага болон өглөгийн зөрүүг нэмж тооцно.

5.4 Тухайн нэг гадаад валютын нээлттэй позици нь өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтрэхгүй байна.

5.5 Нийт нээлттэй позицийг гадаад валют тус бүрийн хувьд тооцсон урт позицуудын нийлбэр, богино позицуудын абсолют нийлбэрийн аль их дүнгээр тодорхойлох бөгөөд энэ үзүүлэлт нь ББСБ-ын өөрийн хөрөнгийн 40 хувиас хэтрэхгүй байна.

Гадаад валютын ханшийн эрсдэлийн тайланг энэхүү журмын зургадугаар хавсралтын дагуу тооцож гаргана.

5.6 Гадаад валютаар санхүүгийн эх үүсвэр бусдаас татан төвлөрүүлээгүй, гадаад валютаар илэрхийлэгдэх актив хөрөнгөгүй ББСБ-ын хувьд энэ үзүүлэлтийг хангаж ажилласан гэж үзэх тул гадаад валютын ханшийн эрсдэлийн үзүүлэлтийг тооцох шаардлагагүй.

ЗУРГАА. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

6.1 ББСБ-ын үйл ажиллагаанд мөрдөгдөх зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтэд Хороо улирал тутам хяналт тавьж, шаардлагатай гэж үзвэл газар дээр нь шалгалт хийж, холбогдох арга хэмжээг авна.

6.2 Аль нэг зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг 2-3 улирал дараалан хангаагүй ББСБ-д Хорооноос баталсан "Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам"-ын 8.2.1, 8.3.4 заалтад заасан арга хэмжээг авна.

6.3 Энэ журмын 2.6.1 дэх заалтын дагуу тооцсон ББСБ-ын өөрийн хөрөнгийн хүрэлцээг дараах байдлаар ангилна. Үүнд:

1/ Нийт өөрийн хөрөнгө, нийт цэвэршүүлсэн активын зохистой харьцаа нь 30 буюу түүнээс дээш хувь, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт цэвэршүүлсэн активын зохистой харьцаа нь 15 буюу түүнээс дээш хувь байгаа ББСБ-ыг зохистой хэмжээний өөрийн хөрөнгөтэй,

2/ Нийт өөрийн хөрөнгө, нийт цэвэршүүлсэн активын зохистой харьцаа нь 15-30 хүртэл хувь, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт цэвэршүүлсэн активын зохистой харьцаа нь 10-15 хүртэл хувь байгаа ББСБ-ыг хангалтгүй өөрийн хөрөнгөтэй,

3/ Нийт өөрийн хөрөнгө, нийт цэвэршүүлсэн активын зохистой харьцаа нь 0-15 хүртэл хувь, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт цэвэршүүлсэн активын зохистой харьцаа нь 0-10 хүртэл хувь байгаа ББСБ-ыг өөрийн хөрөнгийн хэмжээ алдагдаж байгаа,

4/ Нийт өөрийн хөрөнгө нийт цэвэршүүлсэн актив, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө нийт цэвэршүүлсэн активын зохистой харьцаа 0 хувиас бага байгаа ББСБ-ыг өөрийн хөрөнгийн хэмжээ алдагдсан байгууллага гэж тооцно.

6.4 Энэ журмын 2.6.2 дахь заалтын дагуу тооцсон ББСБ-ын өөрийн хөрөнгийн хүрэлцээг дараах байдлаар ангилна. Үүнд:

1/ Нийт өөрийн хөрөнгө, нийт цэвэршүүлсэн активын зохистой харьцаа нь 40 буюу түүнээс дээш хувь, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт цэвэршүүлсэн активын зохистой харьцаа нь 20 буюу түүнээс дээш хувь байгаа ББСБ-ыг зохистой хэмжээний өөрийн хөрөнгөтэй,

2/ Нийт өөрийн хөрөнгө, нийт цэвэршүүлсэн активын зохистой харьцаа нь 20-40 хүртэл хувь, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт цэвэршүүлсэн активын зохистой харьцаа нь 10-20 хүртэл хувь байгаа ББСБ-ыг хангалтгүй өөрийн хөрөнгөтэй,

3/ Нийт өөрийн хөрөнгө, нийт цэвэршүүлсэн активын зохистой харьцаа нь 0-20 хүртэл хувь, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт цэвэршүүлсэн активын зохистой харьцаа нь 0-10 хүртэл хувь байгаа ББСБ-ыг өөрийн хөрөнгийн хэмжээ алдагдаж байгаа,

4/ Нийт өөрийн хөрөнгө нийт цэвэршүүлсэн актив, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө нийт цэвэршүүлсэн активын зохистой харьцаа 0 хувиас бага байгаа ББСБ-ыг өөрийн хөрөнгийн хэмжээ алдагдсан байгууллага гэж тооцно.

6.5 Тус журмын 6.3-ын 2/, 6.4-ийн 2/-д заасан ангилалд хамрагдсан ББСБ-д дараах арга хэмжээ авна. Үүнд:

1/ албан бичгээр анхааруулах;

2/ зөрчлийг арилгах талаар хугацаатай үүрэг, даалгавар өгөх;

3/ дүрмийн санг нэмэгдүүлэхийг шаардах;

4/ салбар, нэгж шинээр байгуулах, нэмэлт үйл ажиллагаа эрхлэхийг хориглох.

6.6 Тус журмын 6.3-ын 3/, 6.4-ийн 3/-д заасан ангилалд хамрагдсан ББСБ-д дараах арга хэмжээ авна. Үүнд:

1/ алдагдал учруулж буй зарим үйл ажиллагааг түр буюу бүрэн зогсоох;

2/ ногдол ашиг хуваарилахыг түдгэлзүүлэх;

3/ бусдаас эх үүсвэр татан төвлөрүүлэхийг хориглох.

6.7 Журмын 6.3-ын 4/, 6.4-ийн 4/-д заасан ангилалд хамрагдсан ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 6 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ.

6.8 Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд Хорооны улсын байцаагчаас өгөгдсөн үүрэг даалгавар, шаардлагыг биелүүлж ажиллаагүй ББСБ-ын үйл ажиллагааны эрхийг хүчингүй болгож, нийтэд мэдээлнэ.

6.9 Хорооноос дээрх арга хэмжээнүүдийг хүлээлгэхдээ адил зөрчилд адил арга хэмжээ авах зарчмыг баримтална.

ДОЛОО. БУСАД

7.1 ББСБ нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг энэхүү журмын хавсралтуудын дагуу улирал бүр тооцож, тайланг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ. Үүнд:

1/ Өөрийн хөрөнгө, нийт цэвэршүүлсэн активын зохистой харьцааны тайлан (Хавсралт 1),

2/ Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын тайлан (Хавсралт 2),

3/ ББСБ-ын том зээлдэгчид олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн тайлан (Хавсралт 3),

4/ ББСБ-ын хувь нийлүүлэгч, өөрийн ажилтан, холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох, бусад актив хөрөнгийн тайлан (Хавсралт 4),

5/ Активын эрсдэлийн сангийн хүрэлцээний үзүүлэлтийн тайлан (Хавсралт 5),

6/ Гадаад валютын ханшийн эрсдэлийн тайлан (Хавсралт 6),

7/ ББСБ-ын тэнцлийн гадуур бүртгэлтэй хүлээж болзошгүй үүрэг, төлбөрийн баталгааны судалгааны тайлан (Хавсралт 7),

7.2 Итгэлцлийн үйлчилгээ, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан ББСБ дээрх тайлангуудыг сар бүрийн 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, ЭРСДЭЛЭЭР ЖИГНЭСЭН НИЙТ АКТИВЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ТАЙЛАН

200..оны... дугаар улирал

/и үй ааи ө өад а а о д/

ҮЗҮҮЛЭЛТҮҮД		Нийт дүн		
А				
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ /АI+АII/				
I 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө /1+2+3+4-5-6+7+(+/-8)/				
1	Ердийн хувьцаа			
2	Нэмж төлөгдсөн капитал (ердийн хувьцаа)			
3	Нөөцийн сан			
4	Тухайн жилийн ашиг			
5	Өнгөрсөн жилийн ашиг			
6	Тухайн жилийн алдагдал			
7	Өнгөрсөн жилийн алдагдал			
	<i>Аүи</i>			
8	Тохируулга*			
Дүн /тохируулга/				
II 2-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө /8+9+10+11+12+(+/-13)/				
8	Давуу эрхтэй хувьцаа			
9	Нэмж төлөгдсөн капитал (давуу эрхтэй хувьцаа)			
10	Дахин үнэлгээний нэмэгдэл			
11	Нийгмийн хөгжлийн сан			
12	Хоёрдогч өглөг			
	<i>Аүи</i>			
13	Тохируулга**			
Дүн /тохируулга/				
Б НИЙТ ЦЭВЭРШҮҮЛСЭН АКТИВЫН ДҮН БI+БИ+БИI+(+/-8,+/-13)		***		
		Эрдлийн	Ня-бо тайлан	Эрсдлээр
I Аёоёауи аүи /1+2+3+4+5+6+7+8+9+10+11/				
1	Бэлэн хөрөнгө	0%		
2	Банкин дахь харилцах, хадгаламж	0%		
3	Бусад санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж	0%		
4	Зээлийн өрийн үлдэгдэл /цэврээр/	100%		
5	Засгийн газрын үнэт цаас, түүнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	0%		
6	Монголбанкны үнэт цаас, түүнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	0%		
7	Бусад үнэт цаас /цэврээр/	100%		
8	Факторингийн тооцооны авлага /цэврээр/	100%		
9	Өмчлөх бусад үндсэн хөрөнгө /цэврээр/	100%		
10	Үндсэн хөрөнгө /цэврээр/	100%		
11	Бусад актив /цэврээр/	100%		
II Өүй өөёёи аааоодд ааи ни ү аүи				
13	Хүлээж болзошгүй үүргүүд /төлбөрийн баталгаа, зээлийн шугам/	100%		
III Аааааа ааёроуи үднйёёёи үүүёёө		100%		
В	I ЗЭРЭГЛЭЛИЙН ӨХ, НИЙТ ЦЭВЭРШҮҮЛСЭН АКТИВЫН ХАРЬЦАА (АI/Б*100%)	****		
Г	БАЙВАЛ ЗОХИХ /ХУВИАР/	****		
Д	БАЙВАЛ ЗОХИХ /ХУВИАР/	****		
Е	ХАРЬЦААНЫ БИЕЛЭГДЭЭГҮЙ ХУВЬ /Г-В/, /Д-В/	****		
Ё	ШААРДЛАГАТАЙ НЭМЭЛТ I ЗЭРЭГЛЭЛИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ (Б*0,2-АI)	****		
Ж	ӨХ, НИЙТ ЦЭВЭРШҮҮЛСЭН АКТИВЫН ХАРЬЦАА (А/Б*100%)	****		
З	БАЙВАЛ ЗОХИХ /ХУВИАР/	****		
И	БАЙВАЛ ЗОХИХ /ХУВИАР/	****		
Й	ХАРЬЦААНЫ БИЕЛЭГДЭЭГҮЙ ХУВЬ /З-Ж/, /И-Ж/	****		
К	ШААРДЛАГАТАЙ НЭМЭЛТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ (Б*0,4-А)	****		

Тайлбар: * журмын 2.4-ийн 1/4/-д заасан тохируулга

** журмын 2.4-ийн 2/3/-д заасан тохируулга

ТАМГА

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал

/нэр/

Ерөнхий ня-бо

/нэр/

Эдийн засагч

/нэр/

“Агайг аогийг нь олгох аргачлалд үзүүлж өгөх зөв аргачлалыг нь олгох зорилгоор
 үйлдвэрлэлд хэрэгжүүлэх аргачлал”-ийг ажилд ашиглаж

ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ТАЙЛАН

200..оны... дугаар улирал

/Илийн өдөр/

ҮЗҮҮЛЭЛТҮҮД		200 оны -р сарын өдөр		
		төгрөг	гадаад валют	бүгд
A ТҮРГЭН БОРЛОГДОХ АКТИВ /A1+A2+A3+A4/				
1	Бэлэн мөнгө			
2	Засгийн газрын үнэт цаас			
3	Монголбанкны үнэт цаас			
4	Банкин дахь харилцаа, хадгаламж			
Б БУСДААС ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГӨ /B1+B2+B3+B4+B5/				
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг			
2	Банкнаас авсан зээл			
3	Бусад санхүүгийн байгууллагаас авсан зээл			
4	Зарим эх үүсвэр			
5	Бусад пассив			
B ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА (A/B*100%)				
Г ЗОХИСТОЙ ХАРЬЦАА		*	*	*
Д ЗОХИСТОЙ ХАРЬЦАА		*	*	*
E ХАРЬЦААНЫ БИЕЛЭГДЭЭГҮЙ ХУВЬ /Г-В/, /Д-В/				
Ё ШААРДЛАГАТАЙ НЭМЭЛТ ТҮРГЭН БОРЛОГДОХ АКТИВ (Б*0,1-A)				

ТАМГА
 Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал /нэр/
 Ерөнхий ня-бо /нэр/

"Агай э аонй пай олззэээй зээ ээеэааааи үү чй оёлотй өадиоааи үү өаеэоод
 зээзээүүө өдйэдйй өдөдэе өөддй " - үй Ооаандэөд з

**ББСБ-ЫН ТОМ ЗЭЭЛДЭГЧИД ОЛГОСОН ЗЭЭЛ, ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАН
 ТООЦОХ БУСАД АКТИВ ХӨРӨНГИЙН ТАЙЛАН**

200..оны ... дугаар улирал

/й үй ааи өөддөд/

Дд	Зээлдэгчийн нэр*	Зээл, зээлтэй ажилтан тооцох бусад актив хөрөнгийн эхний үлдэгдэл	Зориулалт	Олгосон огноо	Төлөгдөх хугацаа	Хугацаа сунгасан төлөгдөх огноо	Барьцаа хөрөнгийн үнэлгээ	Зээл, зээлтэй ажилтан тооцох бусад актив хөрөнгийн тайлант үеийн үлдэгдэл	Активын ангилал	Өөрийн хөрөнгөд эзлэх хувь
	БҮГД									

ТАМГА

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал /нэр/
 Ерөнхий ня-бо /нэр/
 Эдийн засагч /нэр/

“Аайе аон пай оул ааеи үеэ ааеаааааи ү и өнөи ө дадиоааи ү өаеаоод
 үүүүүөөò òìàòîîò òòòàé æòðàì ”-ûí Òààндàèò 5

АКТИВЫН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН

200...оны...дугаар улирал

/1 үг ааи ò°ааò°а°ò°/

	Актив	Үлдэгдэл	Эрсдлийн сангийн хувь	Байгуулбал зохих сан	Байгуулсан сан	Илүү (+) дугуу (-)
1	Хэвийн зээл		* %			
2	Хугацаа хэтэрсэн зээл		* %			
3	Чанаргүй зээл. Үүнээс: а/ Хэвийн бус б/ Эргэлзээтэй в/ Муу		* % * % * %			
4	Хэвийн факторинг		* %			
5	Хугацаа хэтэрсэн факторинг		* %			
6	Чанаргүй факторинг. Үүнээс: а/ Хэвийн бус б/ Эргэлзээтэй в/ Муу		* % * % * %			
7	Хэвийн авлага		* %			
8	Хугацаа хэтэрсэн авлага		* %			
9	Чанаргүй авлага. Үүнээс: а/ Хэвийн бус б/ Эргэлзээтэй в/ Муу		* % * % * %			
10	Үнэт цаас					
11	Хэвийн ӨБҮХХ		* %			
12	Хугацаа ӨБҮХХ		* %			
13	Чанаргүй ӨБҮХХ. Үүнээс: а/ Хэвийн бус б/ Эргэлзээтэй в/ Муу		* % * % * %			
14	Хүлээж болзошгүй үүргүүд /төлбөрийн баталгаа/					
	НИЙТ					

ТАМГА

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал
 Ерөнхий ня-бо
 Эдийн засагч

/нэр/
 /нэр/
 /нэр/

“Агай ё догн ний ольж аеёи эе аеёёеаааааи ү чи бөлгөи ё бадниаааи ү өаеаооо
 эеёеёеёо дийаоийо оодоае аеодоаи ”-ий дааандаеө 7

ТЭНЦЛИЙН ГАДУУР БҮРТГЭЛТЭЙ ХҮЛЭЭЖ БОЛЗОШГУЙ ҮҮРЭГ, ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

200..оны ... дугаар улирал

/и үйааи оааоаоаоао/

Д/д	ДАНС	ААН-ийн нэр	Регистрийн дугаар	Улсын бүртгэлийн дугаар	Баталгааны зориулалт	ААН, байгууллагын захирлын		ББСБ-тай ямар холбоотой эсэх*	Хугацаа		Хугацаа сунгасан огноо	Дүн		Өөрийн хөрөнгөд эзлэх хувь
						Нэр	Регистрийн дугаар		гаргасан	төлөгдөх		төгрөг	Валлот	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15
1	Төлбөрийн баталгаа /нэг бүрээр/													
	БҮГД													
2	Зээлийн шугам /нэг бүрээр/													
	БҮГД													
3	Бусад /нэг бүрээр/													
	БҮГД													
	НИЙТ													

Тайлбар: 1. * - ББСБ-ын хувь нийлүүлэгч бол 1, ТУЗ-ын гишүүн бол 2, Гүйцэтгэх захирал бол 3, ажилтан бол 4, тэдгээрийн холбогдох этгээд бол 5 гэсэн тоогоор тэмдэглэнэ.

2. Бусад гаргасан төлбөрийн баталгаа, баталгаа гаргуулагч тус бүрээр нь судалгаанд хамруулна.

ТАМГА

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал
 Ерөнхий ня-бо
 Эдийн засагч

/нэр/
 /нэр/
 /нэр/